



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iac.mn, Вэб сайт: http://iac.mn

2021.11.24 № 067/12635.

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээллийн технологийн төвийн Програм хангамжийн хэлтэст ахлах референтээр томилогдохоор нэр дэвшэн Пүрэвсүрэнгийн Алтанчимэгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч П.Алтанчимэг нь “Хөөрхөн цэцэгхэн” ХХК-ийн захирлаар бүртгэлтэй байх тул “Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг баримтлан ажиллах нь зүйтэй.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142103021593